



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянзүрх шижир” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/216/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhburtgelaudit8@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 169
танай _____-ны № _____-т

БЯАНЗҮРХ ШИЖИР ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Л.ДАНЗАНРАВЖАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх шижир ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 145.4 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг”, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянзүрх шижир ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 8.6 сая төгрөгийн амралтын үйлчилгээний орлого бүрдүүлж, БЗД-ийн Засаг даргын 2025 оны захирамжаар 76.3 сая төгрөгийн өр барагдуулах санхүүжилт авч, 139.8 сая төгрөгийн зардал гаргаж, 54.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

БЗД-ийн Засаг даргын 2025 оны А/74 дүгээр захирамжаар амралтын газарт гадна дотор засвар, халаалт цахилгааны хэсэгчилсэн шинэчлэл, дээвэр засвар хийх ажил эхэлж, үргэлжлэн явагдаж байна.

Бусад асуудал

Тайлант онд холбогдох дээд шатны байгууллагатай онцгой нөхцөл бүхий гэрээ байгуулаагүй, зорилтот түвшний төлөвлөгөө болон байгууллагын бүтэц, орон тоо батлуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,173.39	17,770.14
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	279,840.41	1,359,662.73
1.1.4	Бусад авлага	-	58,400.00
1.1.6	Бараа материал	17,912,442.19	29,492,868.67
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,205,455.99	30,928,701.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	976,843,222.59	883,271,827.88
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	976,843,222.59	883,271,827.88
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	995,048,678.58	914,200,529.42
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.1	Дансны өглөг	29,562,579.66	37,338,827.63
2.1.1.2	Цалингийн өглөг	22,477,576.35	22,477,576.35
2.1.1.3	Татварын өглөг	21,595,546.78	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	12,073,933.43	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,045,128,180.20	1,045,128,180.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,130,837,816.42	1,104,944,584.18
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	1,130,837,816.42	1,104,944,584.18
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	91,461,287.78	91,461,287.78
2.3.9	Хуримтлагдсан ашиг	- 227,250,425.62	- 282,205,342.54
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	- 135,789,137.84	- 190,744,054.76
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	995,048,678.58	914,200,529.42

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	110,197,454.55	8,636,363.63
2	Борлуусан бүтээгдхүүний өртөг	--	-
3	Нийт ашиг (алдагдал)	110,197,454.55	8,636,363.63
4	Бусад орлого	-	76,300,902.11
9	Борлуулалт, маркетингийн зардал	227,882,285.50	139,862,689.15
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,955,205.90	-
11	Санхүүгийн зардал	-	29,493.50
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	- 119,640,036.50	- 54,954,916.92
20	Татварын дараах ашиг (алдагдал)	- 119,640,036.50	- 54,954,916.92
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	- 119,640,036.50	- 54,954,916.92

1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	91,461,287.78	-	91,461,287.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	- 82,972,225.65	-
3	Залруулсан үлдэгдэл	91,461,287.78	- 227,250,425.62	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-54,954,916.92	-54,954,916.92
9	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	91,461,287.78	-282,205,342.54	-
				190,744,054.76

1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	112,077,200.00	88,135,902.10
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	112,077,200.00	9,500,000.00
	Бусад мөнгөн орлого	-	78,635,902.10
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	112,653,359.12	88,131,305.35
	Ажиллагчдад төлсөн	45,393,147.00	-
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,400,000.00	12,073,940.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	33,665,198.05	12,684,174.00
	Ашиглалтын зардалд төлсөн	4,481,579.31	4,238,100.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,792,462.00	2,776,346.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	2,021,867.07	22,762,901.85
	Бусад мөнгөн зарлага	9,899,105.69	33,595,843.50
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-576,159.12	4,596.75
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,030,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,030,000.00	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
		4,030,000.00	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,817,474.66	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,817,474.66	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,400,000.00	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,400,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,417,474.66	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	120,027.75
		188,684.46	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	600,281.96	13,173.39
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	411,597.50	17,770.14

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145,372.8 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд 1 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөөгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Өр барагдуулах санхүүжилтээр өрийг бүрэн барагдуулаагүй, үйл ажиллагааны зардалд зарцуулсан	1	38,976.3	-	-	1	38,976.3	-	-	-	-	-	-
Ашиглаж байгаа зарим хөрөнгүүд санхүүгийн тайланд бүртгэлгүй, тээврийн хэрэгслийн өмчлөгчийг бүртгүүлээгүй	1	106,396.4			1	106,396.4	-	-	-	-	-	-
Дүн	3	145,372.7		-	2	145,372.7	1	-	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 105,540.9 мянган төгрөгийн 6 зөрчлөөс 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, нийт 105,540.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	105,540.9	-	-	-	-	1	105,540.9
	Дүн	1	105,540.9	-	-	-	-	1	105,540.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
	Байгууллагын бүтэц орон тоо батлуулаагүй, мэргэжлийн нягтлан бодогч томилоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулаагүй, санхүүгийн анхан шатны баримт материал үйлдэж, баталгаажуулаагүй, татварын болон нийгмийн даатгалын тайлан бэлтгэж, тайлагнаагүй, 1 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан.	1	-	-	-	1	-	-	-
	Зорилтот түвшин төлөвлөгөө батлуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-	-	-	1	-	-	-
	Гүйцэтгэх удирдлага дээд шатны байгууллагатай онцгой нөхцөл бүхий гэрээ байгуулаагүй.	1	-	-	-	1	-	-	-
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг ил тодоор мэдээлээгүй	1	-	-	-	-	-	1	-
	Ахмадын сан байгуулаагүй	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	5	-	-	-	3	-	2	-
	Нийт дүн	6	105,540.9	-	-	3	-	3	105,540.9